



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 431.

Улаанбаатар хот

┌ Тогтоол хүчингүй болгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах арга хэмжээний тухай” 258 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2023 оны 258 дугаар тогтоолоор “Цемент шохой” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд ажиллуулж, компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийг тогтоосонтой холбогдуулан “Цемент шохой” ТӨХК-ийн дүрмийг баталсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 110 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ